

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

ИЛТГЭХ ХУУДАС

Удирдлагын зүгээс иргэдтэй хийсэн уулзалтын тухай
2022 оны 03 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Тус төвд хандсан иргэдтэй удирдлагын зүгээс сард 1 удаа уулзаж, тулгарч буй бэрхшээл, авахыг хүссэн үйлчилгээ, санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч цаг алдалгүй шийдвэрлэж хариуг зохих журмын дагуу тухайн иргэнд өгч ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/32 дугаартай захирамжаар тус төвийн даргаар томилогдсон Ш.Мөнхцэцэг нь иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч зорилго бүхий “Сонсьё-Шийдые” арга хэмжээг санаачлан дараах ажлуудыг зохион байгууллаа.

Уг арга хэмжээ нь

-Одоогийн нөхцөл байдалтай танилцах

-Үйлчлүүлэгчийн санаа хүсэлтийг сонсох

-Цаашдын хэрэгцээ, хүслийг сонсох зорилготойгоор зохион байгуулагдсан бөгөөд

- 2022-02-07 -ахмад настан-20
- 2022-02-23-хөгжлийн бэрхшээлтэй иргэд-14
- 2022-02-23-шинэ ирсэн үйлчлүүлэгч-13
- 2022-02-22-олон жил үйлчилгээ авсан-11
- 2022-02-04-төвөөр үйлчлүүлж буй нийт иргэд-95
- 2022-03-28-гэрт байрлаж буй-17 нийт 170 иргэнтэй /1 иргэнтэй 3 удаа/ уулзаж санал хүсэлтийг хүлээн авлаа.

Уулзалтын хүрээнд дараах санал хүсэлтүүд ирлээ.

1. Ажил хийх хүсэлт
2. Эрэгтэй халуун усны өрөөнд угаалгын машин байрлуулах нь усанд ороход хэцүү байна.
3. 2-р хоол идэх
4. Санал хүсэлт авсан ч эргээд хариу хэлдэггүй
5. Ариун цэврийн өрөөг 22.00 цаг гээд цоожлоод байна. Шөнө хэцүү байна гэх санал, хүсэлтийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

1. Ажилд
2. Халуун усны өрөөнд байрлуулсан угаалгын машиныг гаргасан
3. 7 хоногт 3 удаа II хоол өгч хоолны цэсэнд өөрчлөлт оруулсан.
4. Иргэдээс авсан санал, хүсэлтийн хариуг өгч хэвшихийг нийгмийн ажилтнуудад даалгасан.
5. Ариун цэврийн өрөөг нээлттэй байлгаж, цэвэрлэгээ, эд аж ахуйн бүрэн байдалд байнга хяналт тавихыг жижүүрүүдэд тус тус үүрэг болголоо.

